



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/361

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын гаднах дулааны шугам 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр задарсантай холбогдуулан тус цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн болгох зорилгоор тухайн үед хувийн хэвшлийн хөрөнгөөр хийлгэсэн санхүүжилтийг шийдвэрлэхэд зориулан 5 487 000 /Таван сая дөрвөн зуун наян долоон мянга/ -н төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 5 487 000 төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.8-д Хуучирч муудсан шугам сүлжээний засвараас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 24-ний өдрийн
А/361 дүгээр захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН
ГАДНАХ ДУЛААНЫ ШУГАМ СОЛИХ ЗАРДЛЫН ТООЦОО

/Төгрөгөөр/

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт
1	Ф80 оёдолгүй ган хоолой	120	м	39 500	4 740 000
2	Ф80 ган хаалт	2	ш	150 000	300 000
3	Ф80 ган булан	14	ш	12 000	168 000
4	Ф80 филанз	8	ш	10 000	80 000
5	22-ын боолт гайк	32	ш	2500	80 000
6	180-тай ир	20	ш	3000	60 000
7	Электрод	2	ш	22 000	44 000
8	Олс	5	ш	3000	15 000
Нийт					5 487 000

-оОо-